



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_ өдөр

Дугаар 1/181

Номгон

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5 дахь заалт, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймагт хийгдсэн “110/35/10 кВ-ын Баянхонгор дэд станцын өргөтгөл, шинэчлэл /Баянхонгор/” төсөл арга хэмжээний 110/35/10 кВ-ын 16МВТ-ын трансформатор секц 2-ыг 10кВ шилжүүлэх үеийн ажилд техникийн комисс ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: С.Хүрэлхуяг- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга, хот, байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор

Гишүүд: Б.Анхбаяр -“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” Төрийн өмчит ХК-ийн хангайн бүсийн салбарын ерөнхий инженер

А.Ганбат -“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” Төрийн өмчит ХК-ийн хангайн бүсийн салбарын Баянхонгор дэд станцын ахлах инженер

Т.Норовринчин - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалт хэлтсийн дэд бүтэц, барилга, орон сууцны бодлого хариуцсан мэргэжилтэн

Б.Бадамцэцэг - “Баянхонгор Эрчим хүч ЦТ” ХХК-ийн ерөнхий инженер

Д.Гантулга - “Баянхонгор Эрчим хүч ЦТ” ХХК-ийн релин хамгаалалтын инженер

Э.Батбаяр -“Баясалтөгс” ХХК-ийн ерөнхий инженер


Ч.Галбадрах -“ДМТМ” ХХК-ийн ерөнхий инженер

Нарийн бичгийн дарга: О.Батцэцэг - ЭХҮТ ТӨХХК-ийн Захиалагч техник хяналтын хэлтсийн хяналтын инженер

2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн дэд станцын өргөтгөл, шинэчлэлийн ажилд техникийн комисс ажиллаж илэрсэн зөрчлийг арилгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга /С.Хүрэлхуяг/-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Б.Батсуурь/-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

624011195